



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 13/24

Улаанбаатар хот

Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг
шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Компанийн дүрмийн 7.3.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 39 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг хавсралтын дагуу шинэчлэн баталсугай.

2. Удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлт болон нислэг-үйлдвэрлэлийн нэгжийн мэргэшсэн хүний нөөцийг бэхжүүлэхтэй холбогдуулан компанийн үндсэн орон тооны дээд хязгаарыг 1,098 байхаар баталсугай.

3. Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсантай холбогдуулан компанийн нислэг-үйлдвэрлэлийн нэгжүүдийн дотоод зохион байгуулалтыг олон улсын болон Монгол Улсын Иргэний Нисэхийн дүрэмд нийцүүлэн баталж, “Үндсэн зааварт”-т оруулан Иргэний Нисэхийн Ерөнхий газраар баталгаажуулахыг “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал /Б.Мөнхтамир/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Компанийн үндсэн орон тооны дээд хязгаарын батлах тухай” 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02/24, “Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 11/24 дүгээр тогтоолуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



С.БАТБОЛД



"МИАТ" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 43 дугаар тогтоолын хавсралт

"МИАТ" ТӨХК-ийн УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

